



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1/2

Өлгий

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах хүсэлтийг шийдвэрлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 6 дугаар зүйлийн 6.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.12, 13.19 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шинжээчийн бүрэлдэхүүний 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн эрхийг шинээр олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эрх сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6673:2017, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл сунгуулсан клиникт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 01 сарын 16 өдрийн 31 тоот
тушаалын 1 хавсралт

**НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ШИНЭЭР
ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Арай"	Эмийн сан	3 жилээр	2029.03.13

**ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ
СУНГАГДСАН БАЙГУУЛЛАГУУД:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Наз"	Шүдний эмнэлэг	5 жилээр	2030.12.30
2	"Тошлой"	Эмийн сан	5 жилээр	2030.12.30
3	"Айс фарм"	Эмийн сан	5 жилээр	2031.03.07

**ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ 3 САР ХҮРТЭЛ ХУГАЦААГААР
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ:**

1. Өлгий сум 5-р баг "Ушхын" ХХК-ийн "Алау" эмийн сан
2. Өлгий сум 5-р баг "Дарая" ХХК-ийн "Дарая" эмийн сан
3. Өлгий сум 5-р баг "Алпамед" ХХК-ийн "Алпамед" эмийн сан

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ:

1. Өлгий сум 5-р баг "КосКос" ХХК-ийн "КосКос" эмийн сан
2. Өлгий сум 11-р баг "Мөнхийн тун" ХХК-ийн "Мөнхийн тун" эмийн сан
3. Өлгий сум 11-р баг "Бек-Сарана" Хоршоо "Ажар" эмийн сан
4. Өлгий сум 12-р баг "Бескарагай" ХХК-ийн "Дуалы" эмийн сан
5. Өлгий сум 13-р баг "Мунказ" ХХК-ийн "Мунказ" эмийн сан

ТАВ. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМ ХУДАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ СУНГУУЛАХ:

1. Өлгий сум 4-р баг “Байбулган” ХХК-ийн “Байбулган” эмийн сан

ЗУРГАА. ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ СЭРГЭЭХ:

1. Өлгий сум 11-р багт “Маржан” ББХХ-ийн “Маржан” шүдний эмнэлэг

ДОЛОО. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. “Сорон Минж” ХХК-ийн IQ’s clinic арьс, гоо заслын клиник нь Косметик зүү эмчилгээ, Нүүрний зүү эмчилгээ, Гуаша эмчилгээ, Нүүрний бумба эмчилгээ гэх мэт тусламж үйлчилгээг нэмэх хүсэлт.
2. Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн Эргэлтийн эмийн сан нь ЭМДаатгалаас хөнгөлөлттэй эмийн санхүүжилтийг авч чадахгүй байгаа тул Аж ахуйн нэгж байгууллага болгож өөрчлөх хүсэлт.
3. “Дармек” ХХК-ийн “Дармек-2” эмийн сан шинэ орон байранд нүүх хүсэлт.
4. “Ушхын” ХХК-ийн “Ушхын” эмийн сангийн эрхлэгч М.Еркежан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул А.Клараг эрхлэгчээр ажиллуулах хүсэлт.